



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 18/177

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 6.2 дахь зорилтын 1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын 26 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зэвсэгт хүчний мод үргүүлэг-Агроэкологийн сургалтын төв, мод үргүүлгийн газрын үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг яамны Төрийн нарийн бичгийн дарга (бригадын генерал Д.Ганхуяг), Зэвсэгт хүчний Жанжин штаб (бригадын генерал С.Ганбямба)-т тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Н.Пүрэвдорж)-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

13/300/2023

Батлан хамгаалахын сайдын 2023 оны

25 дугаар сарын 31-ны өдрийн

дугаар тушаалын хавсралт

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ МОД ҮРЖҮҮЛЭГ-АГРОЭКОЛОГИЙН СУРГАЛТЫН ТӨВ,
МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Энэхүү журмаар Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төв, Мод үржүүлгийн газруудын удирдлага, зохион байгуулалт, мод, бут, сөөг тарьж, арчлан ургуулах, хангарт хийх, худалдан борлуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар (цаашид “анги” гэх)-ын Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төв, Мод үржүүлгийн газрууд (цаашид “мод үржүүлгийн газар” гэх) энэхүү журмыг дагаж мөрднө.

1.3. Уг журам нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тухайн орон нутгийн байгаль, цаг уурын нөхцөл байдал, өөрийн ангийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн явуулах Мод үржүүлгийн газруудын зохион байгуулалт, сургалт, төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналт, хүлээх хариуцлагыг нарийвчлан тодорхойлсон үндсэн баримт бичиг юм.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт:

2.1. Сургалтын төв, Мод үржүүлгийн газрын төсвийн болон мэргэжлийн удирдлагыг Зэвсэгт хүчний Жанжин штаб, үйл ажиллагааны удирдлагыг Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн Удирдах газар, нэгтгэл, анги, салбар зохион байгуулна.

2.2. Сургалтын төв, Мод үржүүлгийн газрууд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, тогтоосон норм, норматив, ахлах даргын тушаал, захирамжийг үндэслэн үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлнэ.

2.3. Мод үржүүлгийн газрууд үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлэхдээ энэ журмыг мөрддөг болгохоос гадна Монгол Улсын стандартыг баримтална.

2.3.1. MNS 1796: 2011 Улиасны модожсон мөчрийн тайрдас. Ерөнхий шаардлага;

2.3.2. MNS 2392:1977 Ойн зохион байгуулалт, батаксац Ургаа модны нөөцийн өсөлт, өөрчлөлтийн ангилал;

2.3.3. MNS 2418: 2011 Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах, ерөнхий шаардлага;

2.3.4. MNS 2426: 1977 Мод, сөөгийн төрөл, загийг үрзэр тарих;

2.3.5. MNS 3868: 1986 Бургасны модожсон мөчрийн тайрдас;

2.3.6 MNS 5973: 2009 Барилга байгууламж инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зайд, хэмжээ;

2.3.7. MNS 5954:2009 Мод, сөөгийн үр тарилтын чанар. Техникийн шаардлага;

2.3.8. MNS 5995: 2009 Мод, сөөгийн үр. Үрийн чанар албан баталгааны маягт;

2.3.9. MNS 6138: 2018 Мод үржүүлгийн талбай сонгох арга. Техникийн шаардлага;

- 2.3.10. MNS 6139: 2010 Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага;
- 2.3.11. MNS 6140: 2010 Мод, сөөгийн тарьц. Техникийн шаардлага;
- 2.3.12. MNS 6141: 2020 Навчит модны суулгац. Техникийн шаардлага;
- 2.3.13. MNS 6252: 2011 Мод, сөөгийн үр тарих. Ерөнхий шаардлага;
- 2.3.14. MNS 6253-1: 2011 Мод, сөөгийн үрийг тарилтад бэлтгэх. Ерөнхий шаардлага;
- 2.3.15. MNS 6253-3:2011 Мод, сөөгийн үрийг тарьсны дараа арчлах. Ерөнхий шаардлага;
- 2.3.16. MNS 6254: 2011 Мод сөөгийн суулгацыг бойжуулах. Ерөнхий шаардлага;
- 2.3.17. MNS 6258-1:2011 Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага;
- 2.3.18. MNS 6258-2:2011 Мод, сөөгийн суулгац арчлах;
- 2.3.19. MNS 6263:2011 цэцэрлэгжүүлсэн талбайг шалгаж, ашиглалтад хүлээн авах. Ерөнхий шаардлага;
- 2.3.20. MNS 6772:2019 Мод, сөөгийг хэлбэржүүлэх. Техникийн шаардлага;
- 2.3.21. MNS 6773:2019 Мод, сөөгийн суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах. Техникийн шаардлага;
- 2.3.22. MNS 6774:2019 Том мод суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах. Техникийн шаардлага.

2.4. Сургалтын төв, Мод үргүүлгийн газрууд төлөвлөгөөгөө тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаатайгаар төлөвлөх ба энэ нь үндсэн зорилго, зорилтоо хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг болно;

2.5. Сургалтын төв, Мод үргүүлгийн газрууд Зэвсэгт хүчинээс хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах ажлын саналаа 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Зэвсэгт хүчиний Жанжин штабын Материал, техникийн газарт хүргүүлэн, хэрэгжүүлж ажиллана.

2.6. Энэхүү журмаар зохицуулагдаагүй бусад асуудал үүссэн тохиолдолд Зэвсэгт хүчиний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн Удирдах газрын холбогдох албан тушаалтанд мэдэгдэн, өгсөн үүрэг, чиглэлийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг албан бичгээр хүргүүлнэ.

Гурав. Бие бүрэлдэхүүнд агро экологийн сургалт зохион байгуулах

3.1. Нийт бие бүрэлдэхүүнд экологийн боловсрол олгох анхан шатны сургалтыг мэргэжлийн багш, ажилтнаар болон Зэвсэгт хүчиний сургагч багш нараар Сургалтын төв, Мод үргүүлгийн газрын материаллаг баазыг түшиглэн хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хуваарь, тушаалын дагуу зохион байгуулна.

3.2. Анхан шатны экологийн сургалтад хамрагдсан бие бүрэлдэхүүнээс тодорхой тооны бие бүрэлдэхүүнийг сонгон авч (сайн дурын үндсэн дээр өөрөө хүсэлт гаргасан алба хаагчийг нэмэлтээр оруулж болно) тусгай төлөвлөгөөний дагуу дунд шатны сургалтыг зохион байгуулна.

3.3. Дунд шатны сургалтад хамрагдсан алба хаагч нарыг ахисан шатны буюу сургагч багш болгох (бэлтгэх) тусгай төлөвлөгөөгөөр сургалтыг зохион байгуулна.

3.4. Сургалтын төв, Мод үржүүлгийн газрын алба хаагч нарт мэргэжил дээшлүүлэх болон бусад төрлийн сургалтыг мэргэжлийн сургууль, төвүүд, багш нартай хамтран ажиллах гэрээний дагуу буюу шинээр гэрээ байгуулан ажиллаж болно.

3.5. Сургалтад хамрагдсан алба хаагчдад мэргэжлийн үнэмлэх (сертификат) олгож, цаашид Зэвсэгт хүчний болон орон нутагт энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулахад нь мэргэжлийн дэмжлэг үзүүлж болно.

Дөрөв. Мод, бут, сөөгийн тарьц, суулгацыг
үрслүүлэх, цэцэрлэгжүүлэх, бүртгэлжүүлэх, хорогдол тооцох:

4. Сургалтын төв, Мод үржүүлгийн газар нь сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн бааз бөгөөд дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

4.1. *Үрсэлгээ хийх*: Модлог ургамлын үрээр болон мөчрөөр гэсэн хэлбэрээр үрслүүлнэ. Үүнийг технологийн картын дагуу зохион байгуулна.

4.1.1. Модлог ургамлын үрийг түүх хугацаа нь тухайн ургамлын төрөл, зүйлээс хамаарч хавар 3-5 сард, намар 10-12 сард байна. Үрслүүлэх аргачлалыг технологийн картын дагуу зохион байгуулна.

4.1.2. Модлог ургамлыг мөчрөөр үрслүүлэх хугацаа нь эх модноос хавар 3 сард тайралт хийж авна. Суулгац мөчрийг хавар, намрын тариалалтад бэлтгэн зориулалтын сав (зоорь)-д хадгалж, хавар 04 дүгээр сарын 25-аас 06 дугаар сарын 01, намар 09 дүгээр сарын 25-аас 11 дүгээр сарын 01-ний хооронд тариалалтыг хийнэ. Суулгац тариалах аргачлалыг технологийн картын дагуу зохион байгуулна.

4.2. *Цэцэрлэгжүүлэлт*: Мандалын цэцгийг тариалахдаа зориулалтын өвлийн хүлэмжид бэлтгэсэн үрийг үрслүүлж эхлүүлнэ. Үрслүүлэх аргачлалыг технологийн картын дагуу зохион байгуулна.

4.2.1. Мандалын цэцгийн үрсэлгээг 02 дугаар сард эхлүүлж, бойжуулалтын талбайгаас 05 дугаар сарын 15-аас, 06 дугаар сарын 01-ний хооронд тариалах талбайд шилжүүлэн суулгана.

4.3. *Бүртгэлжүүлэх*: Мод, бут, сөөг, тарьц, суулгацыг үрслэгээний талбайгаас бойжуулалтын талбайд шилжүүлэн суулгасны дараа бүртгэлийн карт нээж бүртгэлийг эхлүүлнэ.

4.3.1. Мод, бут, сөөг, тарьц, суулгацыг 1-2 настай болох хүртэл нь тоо ширхэг, нэр төрөл нэг бүрээр нь бүртгэлийн картад тухай бүр нь тэмдэглэл хөтлөн үндсэн талбайд суулгах хүртэл арчилгаа, усалгааг хийсэн талаарх мэдээ, мэдээллийг оруулж өгнө;

4.3.2. Мод, бут, сөөг, тарьц, суулгацыг үндсэн талбайд суулгуулахаар хүлээлгэн өгөхдөө бүртгэлийн картыг мөн адил хүлээлгэн өгнө;

4.3.3. Бүртгэлийн картад байгаа мэдээллийг Зэвсэгт хүчний “Тэрбум мод” веб программд (www.army-terbummod.gov.mn) оруулж өгнө. Веб программд оруулсан мэдээллийн дагуу модыг цаашид арчлан хамгаалах ажлыг зохион байгуулна.

4.4. Хорогдол тооцох: Мод, бут, сөөгийн тарьц, суулгацыг мөчрөөр болон үрээр тарихад хорогдлыг тоог дараах байдлаар тооцно. Энэ нь тарьц, суулгацын төрөл зүйлээс хамаарч харилцан адилгүй байна. Үүнд:

4.4.1. Тарьц, суулгацын 80% түүнээс дээш хувь нь амьдралтай бол шаардлага хангасан;

4.4.2. 75-80 хүртэл хувь нь амьдралтай бол хэвийн. (тариалалтын болон арчилгааны үеийн арга барилд анхаарч, цаашид хэрхэн ажиллах талаар дүгнэлт гаргах);

4.4.3. 75-аас доош хувийн амьдралтай бол шаардлага хангаагүй. (шаардлага хангаагүй тохиолдолд нөхөн тариалалт хийнэ);

4.4.4. Тарьц, суулгацыг га-гаар авч үзвэл мөчрөөр 1 га-д 800–аас доошгүй тарьц, үрээр 1 га-д 900–аас доошгүй тарьц амьдралтай бол шаардлага хангасан гэж үзнэ.

4.4.5. Тарьц, суулгацын тариалалтын ажлын явц, чанар, тоо, хэмжээг намрын тооллогоор тоолон үр дүнг тооцож, нөхөн тариалалт хийн, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт болон байгууллага, аж ахуй нэгж, иргэнд хүлээлгэж өгнө.

Тав. Мод, бут, сөөг, мандлын цэцгийн тарьц, суулгацыг захиран, зарцуулах:

5.1. Тарьц суулгацын хангалтыг дараах байдлаар зохион байгуулна.

5.1.1. Сургалтын төв, Мод үргүүлгийн газраас мод, бут, сөөг, мандлын цэцгийн тарьц, суулгацыг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт болон байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд хүлээлгэн өгөх зөвшөөрөл, хуваарийг Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга баталж, мөрдүүлнэ;

5.1.2. Тарьц, суулгацыг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт болон байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд зах зээлийн үнэлгээнээс доогуур хөнгөлөлттэй үнээр нийлүүлж болох ба энэ зөвшөөрлийг Зэвсэгт хүчний Жанжин штабын Материал, техникийн газрын дарга шийдвэрлэнэ.

5.1.3. Батлагдсан хуваарь, зөвшөөрлийн дагуу тарьц, суулгацыг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт болон байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд хүлээлгэн өгөх ажлын хэрэгжилтийг Зэвсэгт хүчний Материал, техникийн газар зохион байгуулж ажиллана;

5.1.4. Мод, бут, сөөг, мандлын цэцгийн тарьц, суулгацыг эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэн авч, намрын улиралд тооллого хийж хорогдлыг тооцно;

5.1.5. Мод, бут, сөөг, мандлын цэцгийн тарьц, суулгацыг хүлээн авч буй байгууллага, нэгтгэл, анги, салбарууд тээвэрлэлтийн асуудлыг бүрэн хариуцна.

5.2. Тарьц суулгацыг худалдан борлуулах.

5.2.1. Мод, бут, сөөг, мандлын цэцгийн тарьц, суулгацыг зах зээлийн үнээр болон 70 хүртэл хувь бууруулж, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт болон алба хаагч (Батлан хамгаалах салбарын) нарт худалдан борлуулж болно;

5.2.2. Мод, бут, сөөг, мандлын цэцгийн тарьц, суулгацын үнийг тогтоохдоо ижил төрлийн ажил, үйлчилгээ явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн зах зээлд худалдаалж буй үнийн саналыг харгалзан, жишиг үнийн тарифаар худалдаална. Жишиг үнийн тарифыг жил бүр шинэчлэн, Зэвсэгт хүчний Жанжин штабын Материал, техникийн газар батална.

5.2.3. Батлан хамгаалах салбараас бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэнд тарьц, суулгацыг нийлүүлэхдээ бараа бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах тухай гэрээг байгуулан, тухайн үеийн зах зээлийн үнэлгээгээр буюу баталж өгсөн үнийн тарифаар борлуулалт хийж, тухайн мод үржүүлгийн газрыг харьяалах нэгтгэл, ангийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн, мод үржүүлгийн газрын үйл ажиллагаанд зарцуулна.

5.2.4. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт шилжүүлснээс бусад тарьц, суулгацыг зах зээлд худалдан, борлуулж олсон орлогыг Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төв, Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааны зардал болох үр, бордоо, багаж тоног төхөөрөмж, хүлэмж худалдан авах болон ажилчдын урамшуулалд зарцуулж болно.

Зургаа. Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төв, Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааны тайлagnalт

6.1. Төрлийн цэргийн командлал, БИЦУГ-ын сургалтын төв, мод үржүүлгийн газрууд үйл ажиллагааны хэрэгжилтийн хагас жилийн тайланг 06 дугаар сарын 25-ны дотор, бүтэн жилийн тайланг 12 дугаар сарын 10-ны дотор БХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлнэ.

6.1.1. Бусад эрх бүхий албан тушаалтан тайлан, мэдээ ирүүлэх талаар амаар болон бичгээр мэдэгдсэн тохиолдолд дурдсан хугацаанд тайлан мэдээг гаргаж өгнө.

6.2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх төсөл, хөтөлбөр болон Сургалтын төв, Мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааны талаарх мэдээ, судалгааг нэгтгэн харуулах зорилго бүхий Зэвсэгт хүчний “Тэрбум мод” веб (www.army-terbummod.gov.mn) программыг тухай бүр нь хөтлөн явуулна.

6.2.1. Зэвсэгт хүчний “Тэрбум мод” веб программыг хөтлөн явуулахдаа өгүүлбэр тайлан бичлэг гэх мэт байдлаар хийгдсэн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг оруулж өгнө.

**Долоо. Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төв,
Мод үржүүлгийн газрын хүлээх хариуцлага:**

7.1. Алба хаагчид дараах тохиолдолд цэргийн сахилгын дүрэм, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн алба хаагчид холбогдох хууль тогтоомж, дүрмийн дагуу хариуцлага хүлээнэ.

7.3. Сургалтын төв, Мод үржүүлгийн газрын эргэлтийн болон үндсэн хөрөнгийг дутаасан, шамшигдуулсан бол гэм буруутай этгээдээр эд хөрөнгийг төлүүлэнэ.

7.4. Алба хаагч эд хөрөнгийг төлөхөөс татгалзвал холбогдох хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

7.5. Мод, бут, сөөгийн тарьц, суулгацыг Зэвсэгт хүчний Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбарууд 75-аас доош хувийн амьдралтай тариалах үүрэг хүлээх ба шаардлага хангаагүй тохиолдолд нөхөн тариалалтыг өөрийн зардлаар зохион байгуулна.

Найм. Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төв,
Мод үржүүлгийн газарт тавих хяналт

8.1. Сургалтын төв, Мод үржүүлгийн газруудын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

8.1.1. Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг зохион байгуулж холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагааг явуулж буй эсэхэд хяналт, шалгалт, үнэлгээ хийж Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлагад дүнг танилцуулан, цаашид хэрхэн арга хэмжээ авч ажиллах талаар заавар, зөвлөмжийг өгч ажиллах;

8.1.2. Зэвсэгт хүчний Жанжин штабын Материал, техникийн газрын болон Барилга инженерийн цэргийн Удирдах газрын холбогдох албан тушаалтнууд удирдамж, тушаалын дагуу Сургалтын төв, Мод үржүүлгийн газарт шалган туслах ажлыг явуулж, санхүүгийн болон эд аж ахуй, материал хэрэгслийн хангарт, захиран зарцуулалтын байдалд үзлэг, шалгалтыг зохион байгуулж, дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

8.2. Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбарууд Сургалтын төв, Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг шууд удирдлагаар хангаж, өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хяналт явуулж, гарсан үр дүнд, дүн, шинжилгээ хийн удирдлагын болон мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлж ажиллана.

8.3. Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар нь Сургалтын төв, Мод үржүүлгийн газрын үржүүлж буй мод, бут, сөөг, цэцэрлэгжүүлэлт, зүлгийн ургалт болон нэгтгэл, анги, салбаруудад хуваарилагдсан тарьц, суулгацын ургалтад хяналт тавьж ажиллана.

Ес. Бусад (Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах,
хүчингүй болгох)

9.1. Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төв, Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааны журамд дараах тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах болон хүчингүй болгоно. Үүнд:

9.1.1. Монгол Улсын хууль, эрх бүхий байгууллагын холбогдох дүрэм, журам шинэчлэгдсэн, шинээр батлагдсан, хүчин төгөлдөр бус болсон тохиолдолд;

9.1.2. Сургалтын төв, Мод үржүүлгийн газрын бүтэц шинэчлэгдэн цаашид энэхүү журмаар үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон, журмын зарим зүйл заалтыг эсвэл бүхэлд нь өөрчлөх шаардлага гарсан;

9.1.3. Эрх бүхий байгууллагын шаардлага, дүгнэлт гарсан;

9.1.4. Сургалтын төв, Мод үргүүлгийн газрын үйл ажиллагааг зогсоосон, татан буулгасан, цаашид дахин үйл ажиллагаа явуулах боломжгүй гэж үзэн эрх бүхий албан тушаалтны шийдвэр гарсан тохиолдолд энэхүү журмыг хүчингүй болгоно.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ